



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№141 /355/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.08.11

Цаг үе, үйл явдал

УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ЦЭРЭГ-СПОРТЫН “ДӨЛ-2022” ТЭМЦЭЭНИЙ ШИЛДГҮҮД ЭНЭ САРД ТОДОРНО



Батлан хамгаалахын сайдын нэрэмжит улсын аварга шалгаруулах цэрэг-спортын “Дөл-2022” цогцолбор тэмцээнийг улсын хэмжээнд 3 үе шаттай

зохион байгуулж байна. Тус тэмцээний нэгдүгээр үе шат өнгөрсөн 3 дугаар сард эхэлсэн бөгөөд эхний шатанд 1338 багийн 17 мянга гаруй

хүүхэд залуучууд тэргүүн байрын төлөө өрсөлдсөнөөс 2 шатанд 318 баг шалгарчээ.

Улмаар хоёрдугаар шатны шалгаруулалтаар 318 багийн 4100

гаруй хүүхэд залуусаас дараагийн шатанд шилдгийн шилдэг 30 баг шалгарсан юм. Тэгвэл тэмцээний гуравдугаар шатны шалгаруулалт буюу аваргууд энэ сарын 20-27-ны өдрүүдэд тодорно.

Тэмцээн Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвд зохион байгуулагдах бөгөөд тэмцээний бэлтгэл ажил эдгээр өдрүүдэд хангагдаж байна.

Энэ удаагийн цэрэг-спортын “Дөл-2022” цогцолбор тэмцээн Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор Батлан хамгаалахын сайдын нэрэмжит болон зохион байгуулагдаж байгаагаараа онцлог юм.

Тэмцээн зохион байгуулагдах явцад “Дөл-2022” цогцолбор тэмцээний оролцогчид болон хөгжөөн дэмжигчдэд Монгол Улсын Зэвсэгт хүчин болон Төрлийн цэргийн командлалуудын бодлого, үйл ажиллагааг танилцуулах, сурталчлах өдөрлөгүүдийг үе шаттайгаар зохион байгуулна.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 21	🌧️ 11


ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 28	🌧️ 23

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3.192.00	3.200.0
EUR 🇪🇺	3.283.0	3.300.0
CNY 🇨🇳	473.50	476.00
RUB 🇷🇺	49.40	50.00
JPY 🇯🇵	23.40	23.80
KRW 🇰🇷	2.42	2.44

ЗУРХАЙ



2022.08.11 /ПҮРЭВ ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 14

ЗУНЫ АДАГ УЛААГЧИН ХОНЬ САРЫН ТАВАН ШАР МЭНГЭТЭЙ УЛААН БИЧ ӨДӨР

Үс засуулбал:

Эд мал арвидна

НАРАН УРГАХ, ШИНГЭХ: 05.42-20.13

Барилдлага:

Үл тохирох

ШҮТЭН БАРИЛДЛАГА:

САНСАР

Суудал: Ус

Энэ өдөр хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр хууль цааз гаргах, батлах, хэрэглэх, хулгай дээрмийг номхотгох, гэмтнийг шийтгэх, мал адгуус номхруулах, сүм дуганыг сэргээх, бүжиг наадам хийх, цэцэрлэг байгуулах, урлан бүтээхэд сайн. Хувцас эсгэх, шинэ хувцас өмсөх, зөвлөгөө хийх, гөлөг тэжээхэд муу.

Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Хол газар яваар одогсод зүүн зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эд, мал арвидна.

“ЗАМ-2022” СУРГАЛТААС ДАДЛАГЫН СУРГАЛТАД ШИЛЖЛЭЭ

Монгол Улсын Зэвсэгт хүчин болон Япон Улсын Өөрийгөө Хамгаалах Хүчний хамтарсан “Зам-2022” хамтарсан сургалт, дадлагад оролцож байгаа бүрэлдэхүүн онолын сургалтаа амжилттай дуусгаж дадлагын сургалтад шилжлээ. Дадлагын сургалтаар 300 м гаруй сайжруулсан шороон зам, хос хоолой бүхий ус өнгөрүүлэх гүүр хоолой барихаар ажиллаж байна. Монгол, Япон инженерүүд замын хэмжилт хийх,

ус өнгөрүүлэх хоолой барих дадлага чадвараар дээшлүүлж, харилцан туршлага солилцсон үр дүнтэй сургалт дадлага болж байна.

Дадлагын сургалтад Монгол Улсын Зэвсэгт хүчний 5 анги, салбарын 50 цэргийн алба хаагч, 20 гаруй техник, тоног төхөөрөмж, Япон Улсын Өөрийгөө Хамгаалах Хүчний 10 цэргийн алба хаагч оролцож байна.

“ЦЭРГИЙН РАЛЛИ-2022” ТЭМЦЭЭНИЙ СУГАЛАА АМЖИЛТТАЙ ЯВАГДЛАА



Оросын Холбооны Улсын Батлан хамгаалах яамнаас зохион байгуулагддаг “Цэргийн ралли-2022” олон улсын тэмцээн 8 дугаар сарын 12-16-ны өдрүүдэд Увс аймгийн Улаангом хот, 16-22-ны өдрүүдэд ОХУ-ын Бүгд найрамдах Тува Улсын нийслэл Кызыл хотод зохион байгуулагдах гэж байна.

Уралдаан бэлтгэл ажлын төлөвлөгөөний дагуу ОХУ, Монгол, Беларусь, Узбекистан Улсын тамирчид

гарааныхаа дарааллыг сонгох сугалаа сугалсан ба Монгол Улсын Зэвсэгт хүчний баг тамирчид IV гараанд уралдахаар боллоо. Мөн баг тамирчид маань уралдааны техникүүдээ хүлээн авч техник үйлчилгээ хийн тэмцээний өмнөх бэлтгэл ажлаа үргэлжлүүлэн хангасаар байна.

Ахлах дэслэгч Д.БЯМБАБАЯР



КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 592,129,086

Эдгэрсэн

Нийт: 563,986,818

Нас барсан

Нийт: 6,444,786

Цахим шууданд

АГААРЫН ЦЭРГИЙН 3 ДАХЬ САЛБАР ОРОН СУУЦТАЙ БОЛЛОО



Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 321 дүгээр салбарт Зэвсэгт хүчний Хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар албан тушаалын 8 айлын орон сууцыг шинээр барьж ашиглалтад орууллаа.

Тус орон сууцны нээлтийн арга хэмжээнд Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, Агаарын цэргийн командлалын төлөөлөл, Хөвсгөл аймгийн Засаг дарга Ж.Эрдэнэбаясгалан нар оролцоо. Хөвсгөл аймгийн Засаг дарга Ж.Эрдэнэбаясгалан нээлтийн арга хэмжээнд баяр хүргэж хэлсэн үгэндээ хөдөө орон нутгийн анги, салбарт ажиллаж амьдарч байгаа

офицер, ахлагч нарын нийгмийн хамгааллын асуудалд анхаарал хандуулж байдаг БХЯ, ЗХЖШ, АЦК-ын удирдлагуудад талархал илэрхийлээд тус салбарт тогтвор суурьшилтай ажиллаж, амьдрах боломж нөхцөлийг дээшлүүлэх зорилгоор аймгийн засаг даргын нөөц хөрөнгөөс 40,000,000 төгрөгийг хандивлалаа.

Энэ онд Зэвсэгт хүчний Хөгжлийн сангийн хөрөнгөөр Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 305, 321, 328 дугаар тусгай салбаруудад шинээр албан тушаалын найман айлын орон сууцны барилгууд ашиглалтад орсноор 34 цэргийн алба хаагч орон сууцаар хангагдлаа.



МОНГОЛ УЛСЫН ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ АЛБА ХААГЧИД “GARUDA CANTI DHARMA - II”-Д АМЖИЛТТАЙ ОРОЛЦЛОО

Монгол Улсын Зэвсэгт хүчний бүрэлдэхүүн Бүгд Найрамдах Индонез Улсын Богор хотод байрлах “Индонезийн Үндэсний Батлан хамгаалах хүчний энхийг сахиулах сургалтын төв”-д өнгөрсөн сарын 12-ноос 31-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “Garuda Santi Dharma - II” олон улсын энхийг дэмжих ажиллагааны сургуульд амжилттай оролцлоо.

Тус сургуулийн АНУ-ын Энэтхэг-Номхон далайн цэргийн командлал, Даян дэлхийн энхийн санаачилга байгууллага, Бүгд найрамдах Индонез Улсын Зэвсэгт хүчин хамтран бүс нутгийн орнуудын цэргийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, энхийг дэмжих ажиллагааны чадавхыг бэхжүүлэх, бэлэн байдлыг дээшлүүлэх зорилтыг хүрээнд зохион байгуулсан бөгөөд сургуульд 30 орны 850 гаруй цэргийн алба хаагч оролцсон юм.

Сургууль штабын сургалт, чадавхыг хөгжүүлэх сургалт, салаадын хээрийн сургууль гэсэн 3 үндсэн хэсэгтэйгээр зохион байгуулагдлаа.

Монгол Улсын Зэвсэгт хүчнээс Штабын сургалтад багшаар 4, оролцогчоор 4 цэргийн алба хаагч, чадавхыг хөгжүүлэх сургалтын хүрээнд явагдсан эмэгтэйчүүд, энх тайван, аюулгүй байдал сургалтад 2 цэргийн алба хаагч, салаадын хээрийн сургуульд зөвлөх багшаар 1, хичээлийн цэгийн багшаар 2, мотобуудлагын салаа 30 цэргийн алба хаагч нийт 43 цэргийн алба хаагч амжилттай оролцсон юм.

“Garuda Santi Dharma - II” олон улсын энхийг дэмжих ажиллагааны сургуулийн хүрээнд явагдсан штабын сургалтад Монгол, Индонези, Бангладеш, Балба, Филиппин, Өмнөд Солонгос, Малайз, Урагавай, Бруней, Шри Ланка, Вьетнам, Пижи зэрэг 12 улсын 60 орчим цэргийн алба хаагч оролцогчоор, 17 цэргийн алба хаагч багшаар тус тус оролцсон юм.

Үндсэн сургалтыг эхний 3 өдөр нэгдсэн байдлаар онолын хичээлийн хэлбэрээр 24 цаг, цаашид хичээлийн 4 бүлгээр тус тус хуваан зохион байгуулав.

Монгол Улсын Зэвсэгт хүчнээс ЗХЖШ-ын



Ажиллагааны удирдлагын газрын Энхийг дэмжих ажиллагааны хэлтсийн ахлах мэргэжилтэн дэд хурандаа Н.Цогтгэрэл төлөвлөлтийн, Материал, техникийн газрын мэргэжилтэн дэд хурандаа М.Пунсалмаа ар талын, Цэргийн хамтын ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн хошууч Б.Сергей иргэн цэргийн харилцааны, Зэвсэгт хүчний 345 дугаар нэгтгэлийн ажиллагааны офицер дэд хурандаа Д.Цолмонбаяр ажиллагааны хичээлийн цэгийн багшаар ажилласан юм.

Онолын хичээлийг НҮБ-ын Ерөнхий бүтэц зохион байгуулалт, НҮБ-ын Стратегийн төлөвлөлт, Энхийг дэмжих ажиллагаа, түүнтэй холбоотой удирдлагын баримт бичгийг боловсруулах, мөн оперативийн төвшинд ажиллагааны төлөвлөлт, удирдлагыг зохион байгуулах, иргэн-цэргийн харилцааг цэрэг, цагдаа, энгийн иргэд болон олон улсын бусад байгууллагатай хэрхэн

уялдуулан зохион байгуулах талаар “Дэлхийн энхийн ажиллагааны санаачилга хөтөлбөр”-ийн гэрээт багш нар удирдан зохион байгууллаа.

Штабын сургалтад ЗХЖШ-ын Эрүүл мэндийн хэлтсийн мэргэжилтэн хошууч О.Гэрэлмаа, АЦК-ын Улсын нисэхийн хэлтсийн нисэхийн ерөнхий инженер хошууч Э.Мөнх-Эрдэнэ, Цэргийн төв эмнэлгийн Яаралтай мэс заслын тасгийн ахлах эмч хошууч С.Сүхбат, Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн Байлдааны хангалтын офицер ахмад Т.Наранзул нар суралцагчаар оролцсон бөгөөд сургалтын явцад идэвх, санаачилгатай бусад орны офицеруудыг манлайлан оролцов.

Дээрх сургалт нь НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагааны хүчний штаб, секторын штабт штабын офицeroор үүрэг гүйцэтгэх үеийн үндсэн үүрэг, даалгаварт нь бодит цагийн байдлаар ойртуулсан чухал сургалт болж чадсан юм.

Таны сонорт



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ БАТЛАН ХАМГААЛАХЫН
ИХ СУРГУУЛЬ



НЭМЭЛТ ЭЛСЭЛТ ЗАРЛАЖ БАЙНА

Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн Аюулгүй байдлын дээд сургууль нь бакалаврын дараах хөтөлбөрүүдэд нэмэлт элсэлт авч байна. Үүнд:

1. Авто инженерчлэл
2. Авто замын инженерчлэл
3. Электроникийн инженерчлэл
4. Кибер аюулгүй байдал
5. Менежмент
6. Нийтийн удирдлага
7. Эдийн засаг

Жич: Элсэлтийн бүртгэлийг Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн бакалаврын болон мэргэжлийн боловсролын хөтөлбөрийн элсэлтийн журмын дагуу бүртгэнэ. Журмыг тус сургуулийн албан ёсны цахим хуудас (<http://mndu.gov.mn>)- аас харна уу.

Бүртгэл явагдах газар: Үндэсний батлан хамгаалах их сургуулийн хичээлийн нэгдүгээр байр 101 тоот.

Бүртгэлийн хугацаа: 2022 оны 07 дугаар сарын 19-ний өдрөөс 08 дугаар сарын 22-ны хүртэл.

Хөтөлбөр баталгаажуулалт: 2022 оны 08 дугаар сарын 22-ны өдрөөс 24-ны өдрүүдэд Үндэсний батлан хамгаалахын их сургуульд дээр.

Холбоо барих утас: ҮБХИС-ийн Сургалтын хэлтэс: 11453164, 11451820